

ЦАХИМ ХӨГЖЛИЙН БАГЦ ХУУЛИУДЫН ТАЛААР АВСАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Гадаадын иргэн, харьяатын газрын төв, орон нутаг дахь 7 нэгжийн нийт 81 албан хаагч судалгаанд хамрагдсанаас 42 хувь буюу 34 нь эмэгтэй, 58 хувь буюу 47 нь эрэгтэй албан хаагч байна.

Албан хаагчдыг насны бүлэг болон ажилласан жилээр харуулбал:

Насны бүлгээр:

Д/д	25-34 нас		35-44 нас		45-51 нас		55-58 нас	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1	26	32%	37	46%	13	16%	5	6%

Ажилласан жилээр:

Д/д	0.5-5 жил		6-10 жил		11-15 жил		16-20 жил		21-33 жил	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1	19	24%	25	31%	17	21%	14	17%	6	7%

1. Цахим гарын үсгийн тухай хууль /Төрийн болон Албаны нууцын тухай хууль, Харьяатын тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон бусад хуулиудтай зөрчилтэй зүйлүүд байвал энд тусгана уу/

- Цахим гарын үсгийн тухай хууль нь процессын үйл ажиллагаатай уялддаггүй, цагийн бүртгэл, гадуур ажиллах зэрэг албан хэрэгцээнд ашиглагддаггүй;

- Энэ хуулийн 11.1-д “Гэрчилгээг Монгол Улсын иргэн, хуулийн этгээдэд таван жил, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнд түүний оршин суух хугацаагаар, эсхүл гурван жилээс дээш хугацаагаар оршин суух бол гурван жилийн хугацаагаар олгоно” гэж заасан бөгөөд дахин орж ирэхэд нь хуучин гарын үсгийг сэргээх эсэх талаар нарийвчилсан ойлголт байхгүй байгааг журамд тусгах;

- Цахим гарын үсэг хуурамчаар үйлдэх эрсдэлтэй;

- Иргэний гарын үсгээ албаны үйл ажиллагаанд хэрэглэх эсэх талаар тодорхойгүй;

2. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль /Төрийн болон Албаны нууцын тухай хууль, Харьяатын тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон бусад хуулиудтай зөрчилтэй зүйлүүд байвал энд тусгана уу/

- Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 33.2.15 дахь хэсэгт заасан гадаадын иргэний гарын хурууны хээг авах талаар зохицуулсан заалт нь Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалттай зөрчилдөж байгааг хууль, журамд нийцүүлэх;

- Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэгт заасны дагуу гадаадын иргэний оршин суух үнэмлэхэд тусгагдах мэдээллийг ил болон далд хэлбэрээр тусгах талаар зохицуулалт тусгах;

- Хуулиар зөвшөөрсөн мэдээллийг албаны үйл ажиллагаанд хэрэглэхдээ байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаанаас хамаарч тодорхой тусгаагүйгээс зөрчил үүсч болзошгүй;

- Гадаадын иргэний хувийн мэдээллийг ашиглахад ямар тохиолдолд мэдээллийн эзнээс зөвшөөрөл авах ёстой, хэрэв гадаадын иргэнээс зөвшөөрөл авсан бол тэрхүү мэдээллээ устгуулах эрхтэй эсэх зэрэг хэрэгжүүлэхэд тодорхойгүй нөхцөл байдлыг холбогдох журамд тусгах;

- Олон улсын хууль тогтоомжтой зөрчилдөх асуудал байгаа бөгөөд “ICAO Doc9303”, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд албадан гаргагдаж байгаа гадаадын иргэний гарын хурууны хээг гадаадын иргэн, харьяатын байгууллага авахаар заасан байдаг.

- Харьяатын тухай хуулийг шинэчлэх шаардлагатай;

3. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль /Төрийн болон Албаны нууцын тухай хууль, Харьяатын тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон бусад хуулиудтай зөрчилтэй зүйлүүд байвал энд тусгана уу/

- Мэдээллийг ил тод, нээлттэй болгоход зарим мэдээллүүд хоорондоо зөрчилдөж болзошгүйг анхааран дагалдан гарах журмуудад нарийвчилсан зохицуулалтуудыг тусгах;

4. Кибер аюулгүй байдлын тухай хууль /Төрийн болон Албаны нууцын тухай хууль, Харьяатын тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон бусад хуулиудтай зөрчилтэй зүйлүүд байвал энд тусгана уу/

- Кибер аюулгүй байдлын тухай хуулийг дагалдан гарсан Засгийн газрын тогтоолоор баталсан журамд мэдээлэл хариуцагч буюу байгууллагад кибер аюулгүй байдлын ажилтан томилж ажиллуулахаар заасан. Цахим хөгжлийн багц хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд дээрх кибер аюулгүй байдлын асуудал хариуцсан ажилтныг мэдээлэл хариуцагч буюу байгууллагын хэрэгжүүлэх чиг үүргийн хэрэгжилтийг хангуулахад чиглэгдсэн ажилтан болгон өөрчлөх зохицуулалтыг бий болгох;

- Кибер аюулгүй байдлын ажилтан албан тушаалын ямар ангилал зэрэглэлд хамаарах талаар тодорхой заагаагүй. /төрийн жинхэнэ албан хаагч эсвэл төрийн үйлчилгээний албан хаагч/ гэдгийг журамд тодорхой заах;

- Байгууллагын мэдээллийн аюулгүй байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, мэргэжилтний орон тоог бий болгох шаардлагатай.

оо00оо